



УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, ТАНДАЛТЫН АЛБАНЫ 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2026 оны 06-р сарын 05

Улаанбаатар хот

№	Үйл ажиллагаа	Хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
1	Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр зохион байгуулсан үйл ажиллагаа	1. Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх мэдээллийн сарын хүрээнд Эмэгтэйчүүдийн мэс заслын эмч нарын бэлтгэсэн эрүүл мэндийн боловсрол олгох 3 төрлийн мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд түгээсэн бөгөөд иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн./Зураг 1.1/ 2. УХТЭ-ийн Ерөнхий мэс заслын тасаг, Хавдрын хими эмчилгээний хэсэг, Дурангийн төв, Цөмийн оношилгоо эмчилгээ төв, Сэргээн засах эмчилгээний тасаг, Хоол шим тэжээлийн тасаг, НЭМТ-ын алба нар хамтран “ХОДООДНЫ ХАВДРААС СЭРГИЙЛЬЕ” нээлттэй хаалганы өдөрлөгийг 2026.02.04-нд зохион байгууллаа. Өдөрлөгөөр 120 гаруй иргэдэд хавдрын нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө, эмчилгээний хоол зүйчийн зөвлөгөөг өгч хавдраас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хийж тэмдэглэн өнгөрүүллээ. Мөн хавдрын эсрэг өдрийн хүрээнд ерөнхий мэс заслын Э.Баярбат эмч “Ходоодны хавдрын үеийн мэс засал эмчилгээ” сэдвээр богино видео зөвлөгөөг цахим хуудсанд нийтэлсэн. /Зураг 1.2/	98%

		3. Дэлхийн Глаукомын долоо хоног Жил бүрийн 3 дугаар сарын 8–14-ний өдрүүдэд Нүдний даралт ихсэх өвчинтэй тэмцэх дэлхийн 7 хонгийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлэг болон Улсын драмын эрдмийн театр-ын хамтын ажиллагааны хүрээнд театрын ажилтан, албан хаагчдад Нүд судлалын тасгаас урьдчилан сэргийлэх үзлэгийг 2026 оны 03 сарын 04 өдөр зохион байгууллаа. Үзлэгийн үеэр нүдний угийн дурангийн шинжилгээ хийх, хараа шалгах зэрэг оношилгоо хийгдэж, мөн нүдний эрүүл ахуй болон нүдний даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, зөвлөгөөг 76 албан хаагчдад өглөө. Энэхүү үйл ажиллагаа нь нүдний өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг олон нийтэд хүргэхэд чиглэсэн юм. Нүдний өвчлөлөөс сэргийлэх 2 төрлийн видео мэдээллийг цахим хуудсанд нийтэлсэн. /Зураг 1.3/ 4. Бөөр хамгаалах дэлхийн өдрийн хүрээнд “БӨӨРНИЙ АРХАГ ӨВЧНИЙ МЕНЕЖМЕНТ, ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТ” сэдэвт сургалт зохион байгуулсан. Энэ өдрийг тохиолдуулан Бөөр, дотоод шүүрэл судлалын тасгаас зүүн бүсийн аймгууд болох Дорноговь, Говьсүмбэр, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн өрх, сум, дотрын болон бөөр, гемодиализын эмч, сувилагч нарт зориулсан “Бөөрний архаг өвчний менежмент, хяналт, сэргийлэлт” сэдэвт багц цагийн сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалтаар бөөрний архаг өвчнийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх болон өвчтөний хяналт, менежментийг сайжруулах чиглэлээр мэргэжил арга зүйн мэдлэг, мэдээллийг оролцогчдод хүргэлээ. /Зураг 1.4/ 5. “Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих долоо хоног”-ийн хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 17–20-ны өдрүүдэд эмнэлгийн нийт эрэгтэй ажилчдад чиглэсэн цогц арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд “Жендрийн эрх тэгш байдал”, “Эрчүүдийн эрүүл мэнд” сэдэвт сургалтыг зохион байгуулж, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол, хандлагыг сайжруулахад чиглэсэн мэдээллийг хүргэсэн. Мөн эрт	
--	--	--	--

		илрүүлэг, урьдчилан сэргийлэх зорилгоор түрүү булчирхайн үзлэг болон хэт авиан шинжилгээг 2 өдрийн хугацаанд зохион байгуулж, нийт 165 гаруй эрэгтэй ажилтныг хамруулсан байна. Үзлэгийн явцад зарим эрсдэлт тохиолдлыг илрүүлж, цаашид нарийвчилсан оношилгоо, эмчилгээний зөвлөгөөг өгсөн. Үүнээс гадна олон нийтэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд түрүү булчирхайн хоргүй томрол, эрэгтэйчүүдийн үргүйдэл, давсагны хавдрын талаархи 3 төрлийн видео мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим сувгаар түгээж, иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлсэн /Зураг 1.5/. 6. Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Эрүүл мэндийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн хүрээнд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, зөвлөгөө мэдээлэл өгч, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр цогц үйлчилгээг үзүүллээ. Өдөрлөгийн 2 өдрийн хугацаанд нийт 1947 иргэн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, зөвлөгөөнд хамрагдсан байна. Үүнд: • Зүрх судасны эрсдэлийн үнэлгээнд – 126 • Даралт ихсэлтийн илрүүлэгт – 224 • Чих, хамар, хоолойн үзлэгт – 107 • Амны хөндийн үзлэгт – 74 • Хэвлийн эхо шинжилгээнд – 136 • Рентген шинжилгээнд – 102 орчим • Зүрхний бичлэг (ЭКГ) – 126 • Мэдрэлийн эмчийн үзлэг, зөвлөгөө – 303 • Ерөнхий мэс заслын эмчийн үзлэг – 83 • Дотоод шүүрлийн эмчийн зөвлөгөө – 229 • Хоол зүйчийн зөвлөгөө – 250 • Уламжлалт, сэргээн засах эмчийн үзлэг – 289 иргэн тус тус хамрагдсан байна.	
--	--	---	--

		Насны бүлгээр авч үзвэл 18–44 болон 45–64 насны иргэд зонхилон хамрагдсан бөгөөд 65-аас дээш насны иргэд ч мөн идэвхтэй оролцсон байна. Үзлэгийн явцад тодорхой тооны иргэдэд эрсдэл илэрч, нарийн мэргэжлийн эмчид хандах, нэмэлт шинжилгээ хийлгэх зөвлөмжийг өгсөн. Мөн иргэдэд зөв хооллолт, амьдралын зөв хэвшил, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгууллаа. Тус өдөрлөг нь иргэдийн дунд өвчнийг эрт илрүүлэх, эрсдэлийг бууруулах, эрүүл мэнддээ анхаарах хандлагыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан үр дүнтэй арга хэмжээ боллоо /Зураг 1.6/. 7. Гарын эрүүл ахуйн өдөр ДЭМБ-ын мэдээлснээр эмч, эрүүл мэндийн ажилтан гарын эрүүл ахуй сахих нь эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын түвшинг 20-40% хүртэл бууруулах боломжтой гэж үзэж байгаа бөгөөд 2009 оноос хойш жил бүрийн 05 дугаар сарын 5-ны өдөр “Save Lives: Clean Your Hands” уриан дор халдвараас урьдчилан сэргийлэх, ач холбогдолыг дэлхий дахинд таниулах зорилгоор тэмдэглэн өнгөрүүлдэг. 2026 оны тус өдрийг “Action saves lives” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлэхээр зарласан байна. Үүний дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь 2009 оноос хойш жил бүр нийт эрүүл мэндийн ажилтны дунд гарын эрүүл ахуй сахих аяныг жил бүр зохион байгуулдаг бөгөөд 2026 онд "Үйлдэл амь насыг аварна- Гарын эрүүл ахуйг тогтмол сахицгаая" аяныг УХТЭ-ийн нийт эрүүл мэндийн ажилтны дунд зохион байгуулж ажилласан уг ажлын хэсэгт НЭМА-нь цахим хуудсаар гарын эрүүл ахуйн 6 төрлийн постер бэлтгэх, флаш моб бүжгийн зохион байгуулалтад орж ажилласан. Тус гарын эрүүл ахуйн бичлэг нь эмнэлгийн цахим хуудсанд байршуулагдаж олон нийтийн сүлжээнд эерэг сэтгэгдэлийг авсан байна. /Зураг 2.5/ 8. Жил бүрийн 5 дугаар сарын 31-ний өдрийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-аас “Дэлхийн тамхигүй өдөр” болгон тэмдэглэдэг. 2026 онд энэхүү өдрийг “Unmasking the appeal – Countering nicotine and tobacco addiction” буюу “Сонирхол татах өнгөлөн далдлалтыг илчилж,	
--	--	---	--

		никотин ба тамхины донтолттой тэмцье” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэ жилийн аяны хүрээнд Утаат тамхи, электрон тамхины эрсдэл, хор нөлөөний талаар олон нийтэд мэдээлэл түгээх, хүүхэд, өсвөр үеийнхэн, залуусыг донтолтоос урьдчилан сэргийлэхэд анхаарч байна. Энэ жилийн хүрээнд УХТЭ-ийн Уушги Судлалын тасаг, Хүүхдийн тасаг, Нийгмийн эрүүл мэндийн албанаас 2026 оны 06 дугаар сарын 02-ний өдөр иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө мэдээллийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр эмнэлгийн үйлчлүүлэгчид болон иргэдэд тамхины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөгөө өгч, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулав. Мөн тамхинаас гаргах никотинтой наалтыг эмнэлгийн 12 ажилтан, амбулаториор үйлчлүүлж буй 48 хүнд нийт 60 наалтыг тус тус нааж тамхинаас гаргах эмчилгээг эхлүүлсэн. Мөн Аддиктологийн төв, Улсын 2-р төв эмнэлэг, NO VAPE хөдөлгөөнтэй хамтран оролцсон 5-р сарын 31 дэлхийн Тамхины эсрэг өдрийг БГД-ын Байгаль эх цогцолборын өмнөх талбайд 2026 оны 05-р сарын 29-нд хамтран тэмдэглэн өнгөрүүллээ. Уг үйл ажиллагаанд иргэдэд тамхины хор хөнөөлийг таниулах, донтолтын болон уушги, хүүхдийн эмчийн зөвлөгөө өгөх, тамхинаас гарах зөвлөмжийг нийт 70 гаруй иргэдэд өгч ажилласан /Зураг 1.7/.	
2	Сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөө гаргаж жилийн турш сургууль цэцэрлэгүүдтэй хамтран эрүүл	1. Жил бүрийн 02 дугаар сарын 04-нд тохиодог “Хавдрын эсрэг дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан “Өвөрмөц хэрэгцээгээрээ нэгдье” уриан дор ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хавдрын талаарх суурь ойлголт олгох, хавдраас урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн зөв дадал, хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Эхлэл” ерөнхий боловсролын сургуулийн VI-VII-р ангийн 93 сурагчдад 2026 оны 02-р сарын 06-ны өдрийн 14:00 цагт “Хавдрын тухай ойлголт” сэдэвт сургалтыг УХТЭ-ийн хими эмчилгээний эмч Т. Хулан, “Осол гэмтлээс сэргийлэх” тухай сэдэвт сургалтыг УХТЭ-ийн НЭМ-ийн мэргэжилтэн Ө. Ундармаа Эхлэл	98%

мэндийн зөвлөгөө мэдээллийг эмч эмнэлгийн мэргэжилтнүүдтэйг ээ хамтран зохион явуулах /Хавсралт 2./	сургуулийн урлаг зааланд сургалтыг орлоо. Сургалтын үр дүнд: Хавдрын тухай суурь ойлголт, үүсэх шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн талаар мэдлэгтэй болж, Хавдраас урьдчилан сэргийлэх боломжтой энгийн, зөв амьдралын хэв маягийг ойлгож, өдөр тутамдаа дадлуудыг хэрэгжүүлж, Эрүүл мэнддээ анхаарах, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар эерэг хандлага төлөвлөө. /Зураг 2.1/ 2. Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх сарын хүрээнд ЕБС-ын сурагчдад чиглэсэн нотолгоонд суурилсан, хүртээмжтэй, чанартай энгийн эрүүл мэндийн мэдээллийг олон нийт болон эрсдэлт бүлгийн иргэдэд хүргэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд Баянгол дүүргийн эрүүл мэндийн төвийн “Нийгмийн эрүүл мэндийн алба”-ны мэргэжилтнүүд, 141-р сургуулийн эмч, багш нартай хамтран V-VI-р ангийн 350 сурагчдад 2026 оны 02-р сарын 10-нд өглөө, өдөр нийт 4 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар умайн хүзүүний хавдрын талаарх мэдээлэл, мэдлэг бататгах асуулт хариулт, гарын бэлэг, хөгжөөнт тоглоомуудыг тоглож брошур тараах материалуудыг сурагчдад тараан ажиллаа. Сургалтын үр дүнд: Сургуулийн багш нар хүний папиллома вирусийн эсрэг вакцины ач холбогдлыг ойлгож, сурталчилгаа, мэдээллийг хамтран хэрэгжүүлэх байдал нэмэгдсэн, Сургалтад хамрагдсан сурагчид умайн хүзүүний хорт хавдрын эрсдэл, урьдчилан сэргийлэлт, вакцинжуулалтын талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн. ЕБС-ийн сурагчдын дунд умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх мэдлэг нэмэгдэж, эрсдэлээс сэргийлэх хандлага төлөвшинө. /Зураг 2.2/ 3. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас 2007 оноос эхлэн жил бүрийн 03 дугаар сарын 03-ны өдрийг “Сонсгол хамгаалах дэлхийн өдөр” болгон тэмдэглэж ирсэн бөгөөд Монгол Улс 2008 оноос эхлэн жил бүр тодорхой уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. 2026 онд тус өдрийг “Хүүхдийн сонсголыг хамгаалъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. Тус өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд сонсголын алдагдлаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Улсын хоёрдугаар төв эмнэлгийн нийгмийн эрүүл мэндийн алба	
--	--	--

		болон дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: Ерөнхий боловсролын Монгени сургуулийн дунд ангийн 80 гаруй сурагчдад сонсгол хамгаалах, хэт чанга дуу чимээний сөрөг нөлөө, сонсголоо хамгаалах зөв дадал хэвшлийн талаар сургалт зохион байгуулсан. Тус сургалтыг УХТЭ-ийн Толгой, хүзүү, чих хамар хоолойн нөхөн сэргээх мэс заслын тасгийн эрхлэгч А.Арсалт эмч удирдан явуулж, сурагчдад сонсголын эрүүл мэндийн талаарх мэдээлэл, зөвлөгөө өгч, асуулт хариултын хэлбэрээр мэдлэгийг бататгасан. /Зураг 2.3/ 4. Улсын драмын эрдмийн театрын албан хаагчдад 2026 оны 04 сарын 23 өдөр нийт 55 хүнд хавдраас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт зохион байгуулсан. Сургалтын хүрээнд хавдрын эрсдэлт хүчин зүйлс, эрт илрүүлгийн ач холбогдол, урьдчилан сэргийлэх боломжуудын талаар мэдээлэл өгч, өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх эрүүл зан үйлийг сурталчилсан. Мөн эрүүл зохистой хооллолтын талаарх энгийн, хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжүүдийг хүргэж, хүнсний бүтээгдэхүүний зөв сонголт хийх, шим тэжээлийн тэнцвэртэй хэрэглээг хэвшүүлэх, жимс, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх, давс, сахар, өөх тосны зохистой хэрэглээний талаар зөвлөгөө өгсөн. Сургалтаар оролцогчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэв. /Зураг 2.4/ 5. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүрийн 05-р сарын 05-ны өдрийг Дэлхийн “Гарын эрүүл ахуйн” өдөр болгон тэмдэглэж ирсэн бөгөөд “Save Lives: Clean Your Hands” уриан дор халдвараас урьдчилан сэргийлэх, ач холбогдлыг дэлхий дахинд таниулах зорилгоор тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэхүү тэмдэглэлт өдрийн хүрээнд Монгени цогцолбор сургуулийн I-Vp ангийн 630 сурагчдад гарын эрүүл ахуйн талаар мэдээллийг сурагчдад түгээж, буруу ойлголтыг бууруулж сургалт сурталчилгаа нөлөөлөл өдөрлөгийн ажлыг зохион байгууллаа. Сургалтаар сурагчид гараа зөв дарааллын дагуу угааж, гараар дамжих халдваруудын тухай мэдэж авч найз нөхдөдөө болон гэрийнхэндээ сануулж хэлж цаашид гараа тогтмол угааж байх талаар	
--	--	--	--

		ярилцлаа. Сургалтын үр дүнд: Сурагчид гарын эрүүл ахуйн талаар зөв мэдлэгтэй болсон. Халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай ойлголттой болсон Гараа зөв, тогтмол угаах дадал хэвшинэ.Сургалтын оролцоо нэмэгдэж, сонирхолтой хэлбэрээр мэдлэг олж авав. Сурагчид сурсан мэдлэгээ гэр бүл, найз нөхдөд гэрийнхэндээ түгээх боломж бүрдсэн./Зураг 2.5/	
3	Цахим хуудсанд цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллийг бэлтгэн нийтлэн ажиллах	1. Улсын хоёрдугаар эмнэлгийн цахим хуудасны үзэлтийг авч 01-р сарын 01-ээс 01-р сарын 31-ны хооронд авч үзвэл 40.5% нь манай эмнэлгийн дагагчид бол 52.2% нь дагагч биш үйлчлүүлэгчид цахим хуудсанд хандан мэдээ мэдээллийг авсан байна. Цахим хуудасны агуулгын төрлөөр үйлчлүүлэгчдийн үзэлтийг авч үзэхэд зурагт мэдээлэл болон постер хамгийн их үзэлттэй буюу 45.6% нь үзсэн байна. Мөн энэ сард цахим хуудсанд шинээр 810 үйлчлүүлэгч дагаж мэдээ мэдээллээ идэвхтэй цахим хуудсан дээр оруулан ажилласан байна. 2. Улсын хоёрдугаар эмнэлгийн цахим хуудасны үзэлтийг авч 02-р сарын 01-ээс 02-р сарын 28-ны хооронд авч үзвэл 42.6% нь манай эмнэлгийн дагагчид бол 57.4% нь дагагч биш үйлчлүүлэгчид цахим хуудсанд хандан мэдээ мэдээллийг авсан байна. Цахим хуудасны агуулгын төрлөөр үйлчлүүлэгчдийн үзэлтийг авч үзэхэд рийл буюу богино бичлэг хамгийн их үзэлттэй буюу 52.5% нь үзсэн байна. Мөн энэ сард цахим хуудсанд шинээр 780 үйлчлүүлэгч дагаж мэдээ мэдээллээ идэвхтэй цахим хуудсан дээр нийтлэн, мэдээллэн ажилласан байна. 3. Эхний улирлын хувьд цахим хуудсаар “Хальтаргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх”, “Осголт хөлдөлтөөс сэргийлэх”, “Архи согтууруулах ундааны хор хөнөөл, хордлого”, “Угаарын хий”, “Томуу, томуу төст өвчнүүдээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө мэдээлэл асаргаа сувилгаа”, “Умайн хүзүүний хавдрын эсрэг мэдээллэх сарын тухай эрүүл мэндийн мэдээлэл”, “Хавдрын тухай ерөнхий ойлголтын мэдээлэл” “Эрчүүдийн эрүүл мэндийн дэмжих 7 хоногийн хүрэн дэх эрүүл мэндийн мэдээллүүд”, “Сар шинийн өдрүүдэд хэрхэн зөв зохистой хооллох, хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх”, “Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх”, “Сонсгол	100%

		хамгаалах дэлхийн 7 хоногийн хүрээнд” гэх мэт эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд болон цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллүүдийг зурагт мэдээлэл, постер, рийл, видео шторк хэлбэрүүдээр цахим хуудсанд нийтлэн ажиллаа. 4. Нийгмийн эрүүл мэнд тандалтын албаны мэргэжилтнүүдийн бэлтгэсэн 185 төрлийн постер мэдээлэл, 43 видео шторк, рийл хэлбэрийн бичлэгнүүдийн эхний улиралд нийтлэн ажиллаж хагас жилийн байдлаар УХТЭ-ийн цахим хуудсыг шинээр 4624 үйлчлүүлэгч дагаснаар 2026 оны 06-р сарын 05-ны өдрийн байдлаар 61.559 дагагчидтай болж өмнөх оны дагагчдын тоог 118.654 үйлчлүүлэгчээр нэмсэн гүйцэтгэлтэй байна. /Зураг 3.1/	
4	Эмнэлгийн Доктор эрдмийн зэрэгтэй эмч, мэргэжилтэн болон Гавьяат цол шагналтай эмч, сувилахуйн мэргэжилтэнг алдаршуулах үйл ажиллагааг цахим хуудсанд нийтлэх	Нийгмийн эрүүл мэндийн албанаас Улсын хоёрдугаар төв эмнэлэгт ажиллаж буй докторын (Ph.D) эрдмийн зэрэгтэй эмч нарыг алдаршуулах, олон нийтэд таниулах зорилгоор “7 хоногт 1 доктор” цуврал мэдээллийн ажлыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд доктор эмч нарын мэргэжлийн чиглэл, ажлын туршлага, амжилт, судалгааны чиглэлийг багтаасан танилцуулга, постерыг бэлтгэн байгууллагын цахим хуудсаар тогтмол түгээсэн. Тайлант хугацаанд нийт 6 доктор эмчийн танилцуулгыг бэлтгэн нийтэлж, байгууллагын хүний нөөцийн чадавх, мэргэжлийн түвшинг олон нийтэд сурталчилсан. Энэхүү үйл ажиллагаа нь эмч нарын үнэлэмж, нэр хүндийг нэмэгдүүлэхээс гадна байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэлийг бэхжүүлэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлсэн /Зураг 4.1/.	95%
5	НЭМҮТ, ЭМЯ-ны гаргасан зөвлөгөө мэдээллүүдийг УХТЭ-ийн цахим хуудсан дээр	Нийгмийн эрүүл мэнд тандалтын албаны мэргэжилтнүүдийн бэлтгэсэн 185 төрлийн постер мэдээлэл, 43 видео шторк, рийл хэлбэрийн бичлэгнүүдийн хагас жилд нийтлэн ажиллаж хагас жилийн байдлаар УХТЭ-ийн цахим хуудсыг шинээр 4624 үйлчлүүлэгч дагаснаар 2026 оны 06-р сарын 05-ны өдрийн байдлаар 61.559	98%

	нийтэлж иргэдэд зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллах	дагагчидтай болж өмнөх оны дагагчдын тоог 118.654 үйлчлүүлэгчээр нэмсэн гүйцэтгэлтэй байна. /Зураг 5.1/ Цахим хуудасны дэлгэрэнгүй хандалтын тайланг хавсралт хэсэгт оруулав /Хавсралт 1/.	
6	Эмнэлгийн амбулаторын хүлээлгийн хэсэгт Нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн самбар ажлуулах	1. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн төслийн хүрээнд явуулын электрон дэлгэцийг Эрүүл мэндийг дэмжих төвд байршуулан ашиглалтад оруулсан. Тус дэлгэцээр Эрүүл мэндийн яамнаас бэлтгэн хүргүүлсэн эрүүл зан үйл төлөвшүүлэх, өдөр тутмын эрүүл мэндийн зөв дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн зөвлөмж, зөвлөгөө бүхий видео шторкуудыг тогтмол давтамжтайгаар иргэдэд хүргэн ажилласан.	90%
7	Үйл ажиллагаанд хамртан оролцсон тухай.	1. Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан холбогдох журам, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль зохион байгуулах тухай” А/115 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн “Гамшгаас хамгаалах Команд штабын сургууль зохион байгуулах тухай” А/151 дүгээр тушаалын хүрээнд эрүүл мэндийн салбарын “Гамшгаас хамгаалах команд штабын сургууль” орон даяар эхэлж УХТЭ-ийн хамт олон Уг сургуульд УХТЭ-ийн мэргэжлийн ангийн штабын бүрэлдхүүн ЭМЯ дээр, эмнэлэг дээр байрлах "Шуурхай штаб, Хөдөлгөөнт багууд нөхцөл байдалд бэлэн ажиллаж 3 өдрийн турш оролцлоо. /Зураг 7.1/ 2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүрийн 05-р сарын 05-ны өдрийг Дэлхийн “Гарын эрүүл ахуйн” өдөр болгон тэмдэглэж ирсэн бөгөөд “Save Lives: Clean Your Hands” уриан дор халдвараас	

		урьдчилан сэргийлэх, ач холбогдлыг дэлхий дахинд таниулах зорилгоор тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэхүү тэмдэглэлт өдрийн хүрээнд “Гарын эрүүл ахуй - Амь нас аварна” сэдэвт богино видео контентын уралдаанд халдвар судлаач эмч нартай хамтран уралдааны бичлэгч оролцох эмч сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг зохион байгуулах, бэлтгэх үйл ажиллагаанд хамтран ажиллаж, уралдааны дэд байрыг эзэлсэн амжилтыг үзүүллээ. /Зураг 7.2/ 3. Нийгмийн эрүүл мэндийн алба нь Олон улсын сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан арга хэмжээг хариуцан ажилласан. Арга хэмжээний хүрээнд эмч, ажилтан болон дэмжих албадын хамтын оролцоотойгоор санхүүжилтийг бүрдүүлж, 2026 оны 5 дугаар сарын 11-ний өглөө нийт 250 сувилагч, тусгай мэргэжилтнийг хүндэтгэлтэйгээр угтан авах үйл ажиллагааг хийсэн.. Тус үйл ажиллагааны үеэр сувилагч, тусгай мэргэжилтэн бүрт сарнай цэцэг, өглөөний цай болон сувилагчийн дүрстэй бэлэг дурсгалын бамбарууш гардуулсан. НЭМА-аас арга хэмжээг зохион байгуулах ажлыг голлон хариуцаж, санхүүгийн дэмжлэг цуглуулах, цэцэг, бамбарууш, өглөөний буфет цай захиалах, арга хэмжээний том хэмжээний баннерын загвар боловсруулж хэвлүүлэх зэрэг ажлуудыг холбогдон хэрэгжүүлсэн. /Зураг 7.3/	
8	Оролцсон үйл ажиллагаанууд	1. АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн 70 жилийн ойн хүрээнд "Гурван цагийн хэлхээс" эрүүл мэндийн нийгмийн ажилтан мэргэжлээр суралцаж буй оюутан, төгсөгч, багш нарын дунд уулзалт, хэлэлцүүлэгт НЭМТА-ны мэргэжилтнүүд оролцож хуулийн төсөлд санал санаачилга дэвшүүлэн оролцлоо. /Зураг 8.1/ 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөг-2026 үйл ажиллагаад УХТЭ-ийг төлөөлөн Сувилахуйн алба, Сургалт гадаад харилцааны алба, Нийгмийн эрүүл мэндийн албаныхан хамтран эмнэлгээ сурталчлах таниулах, ажлыг байрыг санал болгох өдөрлөгт 04-р сарын 16-ны өдөр амжилттай оролцлоо. /Зураг 8.2/	

		3. “Эрүүл Монгол эр хүн” үндэсний чуулга уулзалтын хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт Бөөрний мэс заслын тасгийн эрхлэгч А.Ханхонгор, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн Ч.Гүнчинхорлоо нар оролцсон. /Зураг 8.3/ 4. АШУҮИС-ийн Эрдмийн чуулган-68 "НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР" хуралдаанд НЭМТА-ны мэргэжилтэн Ө. Ундармаа “Оюутнуудын халдварт бус өвчинд нөлөөлөх анхдагч зарим эрсдэлт хүчин зүйлийг тодорхойлох нь” сэдэврт илтгэл хэлэлцүүлж амжилттай оролцлоо. /Зураг 8.4/ 5. Бидний ирээдүй- хүн төвтэй нийтийн эрүүл мэнд нээлттэй хэлэлцүүлэгт УХТЭ-ийн даатгалын алба, НЭМТА, амбулаторийн тасгийн эмч сувилагч, мэдээлэл технологийн албаны мэргэжилтнүүд тусгаар тогтнолын ордонд 05-р сарын 12-ны өдөр оролцож нээлттэй хэлэлцүүлэг болон чөлөөт ярилцлагыг хийлээ. /Зураг 8.5/	
9	Шинээр санаачилсан онцлох ажил	УХТЭ-ийн Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал Д. Цогт-Очирын санаачилгаар НЭМТА-ы мэргэжилтнүүд нь Дэмжих албадын үйл ажиллагааны хэрэгжилтийг улирал бүр цахим сонин мэдээ болгон эмнэлгийнхээ эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд хүргэх танилцуулах, тэдний үйл ажиллагааг бусдад ажилтнууддаа суртачлах зорилгоор улирал бүр уг сонинг нийтлэж байхаар төлөвлөн эхний улирлын сонингоо нийтлэн ажиллаж байна. /Зураг 9.1/	
10	Нийт	Нийгмийн эрүүл мэнд тандалтын албаны хагас жилийн үйл ажиллагааны үнэлгээ дүгнэлт.	95%

ДҮГНЭЛТ:


2026 оны эхний хагас жилийн хугацаанд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Нийгмийн эрүүл мэнд, тандалтын алба нь төлөвлөгөөт үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, нийт үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээгээр 95 хувийн гүйцэтгэлтэй ажиллалаа.

Нийгмийн эрүүл мэнд, тандалтын алба нь хагас жилийн хугацаанд эрүүл мэндийг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр нийт 10 үндсэн чиглэлийн хүрээнд олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд, сургалт, өдөрлөг, урьдчилан сэргийлэх үзлэг, цахим мэдээллийн ажлуудыг тасаг нэгжүүд болон хамтран ажиллагч байгууллагуудтай уялдуулан зохион байгуулж ажилласан. Дараах ажлын хугацаанд сургууль, албан байгууллага болон олон нийтэд чиглэсэн сургалт, сурталчилгааны үйл ажиллагаагаар 1,200 гаруй сурагч, ажилтан, иргэдийг хамруулж, эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн ажлыг хэрэгжүүлсэн. Мөн “Эрүүл мэндийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр нийт 1,947 иргэнийг эрүүл мэндийн үзлэг, эрсдэлийн үнэлгээ, зөвлөгөөнд хамруулж, эрсдэлтэй тохиолдлуудад цаашдын оношилгоо, хяналт, эмчилгээний зөвлөмж өгсөн байна.

Цахим эрүүл мэндийн боловсрол олгох ажлын хүрээнд нийт 185 төрлийн постер мэдээлэл, 43 видео шторк, рийл контентыг бэлтгэн түгээж, байгууллагын цахим хуудсанд шинээр 4,624 хэрэглэгч нэмэгдэн, нийт дагагчийн тоо 61,559 хүрсэн нь байгууллагын мэдээллийн хүртээмж, олон нийтийн оролцоо, цахим нөлөөллийг нэмэгдүүлсэн байна.

Мөн байгууллагын хүний нөөцийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор “7 хоногт 1 доктор” цуврал ажлыг хэрэгжүүлэн нийт 6 доктор эмчийг алдаршуулж, эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн туршлага, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан. Түүнчлэн шинээр санаачлан хэрэгжүүлсэн ЦАХИМ СОНИН, дотоод мэдээллийн ажлууд нь байгууллагын дотоод харилцаа, мэдээллийн урсгалыг сайжруулахад эерэгээр нөлөөлхүйц ажил болсон.


ХАВСРАЛТ ЗУРАГ 1.1




ЗУРАГ 1.2



ЗУРАГ 1.3





ЗУРАГ 1.4



ЗУРАГ 1.5



ЗУРАГ 1.6



ЗУРАГ 1.7





ЗУРАГ 2.1



ЗУРАГ 2.2



ЗУРАГ 2.3





ЗУРАГ 2.4




ЗУРАГ 2.5



ЗУРАГ 3.1





**Улсын Хоёрдугаар
Төв Эмнэлэг**

61M дагагчид • 53 хүн дагаж байгаа
Verified
Орон нутгийн бизнес

Мэргэжлийн хянах самбар
Засах Сурталчлах

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД ТАНДАЛТЫН АЛБА
ЦАХИМ ХУУДАСНЫ ТАЙЛАН

2026 оны 06-р сарын 02

Улаанбаатар хот

2026 ОНЫ 05-Р САР

№	Он	Цахим хуудасны өмнөх сарын дагагчдын тоо	Цахим хуудасны одоогийн дагагчдын тоо	Дагахаа больсон хүний тоо	Шинээр дагасан хүний тоо	Оруулсан нийтлэлийн тоо	Оруулсан бичлэг, шторжны тоо	Үзсэн хүний тоо	Өмнөх сараас нэмэгдсэн, буурсан үзүүлэлт
1	2025 оны 1-р сар	57095	57936	173	810	48	9	818.079	+0
2	2026 оны 02-р сар	57936	58702	134	780	18	11	559.176	-26
3	2026 оны 03-р сар	58702	59696	139	1221	45	7	773.211	+33
4	2026 оны 04-р сар	59696	60.283	114	589	36	9	365.404	-43
5	2026 оны 05-р сар	60.283	61.499	140	1224	38	7	1.221.113	+165
6	Нийт	60.283	61.499	700	4624	185	43	3.736.983	+165

ЗУРАГ 4.1



**УЛСЫН
ХОЁРДУГААР**
ТӨВ ЭМНЭЛЭГ

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРДЭМТЭН
ЭМЧ НАРЫН ТАНИЛЦУУЛГА**



Б. ЭРДЭНЭБУЛГАН
Анагаах ухааны доктор, дэд профессор
Ангиографи, Дүрс оношилгооны
Зөвлөх зэргийн эмч

ЭРДЭМ СУДЛАЛЫН БҮТЭЭЛҮҮД

Бүтээлийн хэлбэр	Хаана	Тоо	Нийт тоо
Эрдэм шинжилгээний өгүүлэл	Гадаад	14	71
	Дотоод	57	
Эрдэм шинжилгээний илтгэл	Гадаад	38	81
	Дотоод	43	
Scopus мэдээллийн санд индексжүүлэгдсэн олон улсын сэтгүүл			12
Удирдаж байсан магистр			2
Удирдаж байсан доктор			2
Ном, гарын авлага			10
Хянан тохиодуулсан ном			4
Шинэ бүтээл, оновчтой санал, ашигтай загвар			3
Нэг сэдэвт бүтээлийн шүүмж			2
Хэрэгжүүлсэн Олон улсын төсөлт ажил			3
Монгол улсын стандарт, удирдамж			4
Ишлэл (citation)			416
Нийт бүтээлийн тоо			610

Second State Central Hospital



**УЛСЫН
ХОЁРДУГААР**
ТӨВ ЭМНЭЛЭГ

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРДЭМТЭН
ЭМЧ НАРЫН ТАНИЛЦУУЛГА**



П. ДУЛАМРАГЧАА
Анагаах ухааны доктор, дэд профессор,
Мэдрэл судлалын Зөвлөх зэргийн эмч

ЭРДЭМ СУДЛАЛЫН БҮТЭЭЛҮҮД


Бүтээлийн хэлбэр	Хаана	Тоо	Нийт тоо
Эрдэм шинжилгээний өгүүлэл	Гадаад	6	115
	Дотоод	109	
Эрдэм шинжилгээний илтгэл	Гадаад	4	19
	Дотоод	15	
Удирдсан магистр			1
Ном, гарын авлага			3
Шинэ бүтээл, оновчтой санал, ашигтай загвар			1
Хэрэгжүүлсэн Олон улсын төсөлт ажил			1
Монгол улсын стандарт, удирдамж			5
Нийт бүтээлийн тоо			144

Second State Central Hospital



**УЛСЫН
ХОЁРДУГААР**
ТӨВ ЭМНЭЛЭГ

**УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРДЭМТЭН
ЭМЧ НАРЫН ТАНИЛЦУУЛГА**



Т. ЛХАГВА-ОЧИР
Анагаах ухааны доктор,
Зөвлөх зэргийн эмч

ЭРДЭМ СУДЛАЛЫН БҮТЭЭЛҮҮД

Бүтээлийн хэлбэр	Хаана	Тоо	Нийт тоо
Эрдэм шинжилгээний өгүүлэл	Гадаад	8	43
	Дотоод	35	
Эрдэм шинжилгээний илтгэл	Гадаад	18	32
	Дотоод	14	
Ном, гарын авлага			2
Хянан тохиодуулсан ном			1
Нэг сэдэвт бүтээлийн шүүмж			2
Хэрэгжүүлсэн Олон улсын төсөлт ажил			6
Монгол улсын стандарт, удирдамж			39
Нийт бүтээлийн тоо			125

Second State Central Hospital



Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг
Published by Ч. Гүнцэ
Нэгдүгээр сарын 9

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЭРДЭМТЭН ЭМЧ НАРЫН ТАНИЛЦУУЛГА.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Амбулаторын тасгийн Хавдрын зөвлөх эмч, Анагаах ухааны доктор, Зөвлөх зэргийн эмч Т. Лхагва-Очир.

Судалгааны бүтээлүүд 210 ишлэл (citations) авч, h-index 5.

Т.Лхагва-Очир эмч нь хавдрын молекул биологи, бай эмчилгээ (target therapy), дархлаа эмчилгээ (immunotherapy)-ний чиглэлээр судалгаа, практикийг хослуулан хавдрын молекул биологи, генетикийн түвшний өөрчлөлтүүдэд тулгуурласа... [Цааш үзэх](#)

Засах Нийтлэлийг дэмжих

400 44 25

Таалагдлаа Сэтгэгдэл Хуваалцах

Хамгийн их холбогдолтой

Yogii Demid Amjilt naiz ...

9 долоо хоног Таалагдлаа Хариулах Нуух

Dundaa Dundaa

Activate Windows
Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг-н өм...
Go to settings to activate Windows.

ЗУРАГ 5.1



Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг

61М дагагчид • 53 хүн дагаж байгаа

Verified

Орон нутгийн бизнес

Мэргэжлийн хянах самбар

Засах Сурталчлах

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД ТАНДАЛТЫН АЛБА
ЦАХИМ ХУУДАСНЫ ТАЙЛАН


2026 оны 06-р сарын 02

Улаанбаатар хот

2026 ОНЫ 05-Р САР

№	Он	Цахим хуудасны өмнөх сарын дагагчдын тоо	Цахим хуудасны одоогийн дагагчдын тоо	Дагахаа больсон хүний тоо	Шинээр дагасан хүний тоо	Оруулсан нийтлэлийн тоо	Оруулсан бичлэг, шторкны тоо	Үзсэн хүний тоо	Өмнөх сараас нэмэгдсэн, буурсан үзүүлэлт
1	2025 оны 1-р сар	57095	57936	173	810	48	9	818.079	+0
2	2026 оны 02-р сар	57936	58702	134	780	18	11	559.176	-26
3	2026 оны 03-р сар	58702	59696	139	1221	45	7	773.211	+33
4	2026 оны 04-р сар	59696	60.283	114	589	36	9	365.404	-43
5	2026 оны 05-р сар	60.283	61.499	140	1224	38	7	1.221.113	+165
6	Нийт	60.283	61.499	700	4624	185	43	3.736.983	+165

ЗУРАГ 7.1







ЗУРАГ 7.2



ЗУРАГ 7.3



ЗУРАГ 8.1




ЗУРАГ 8.2



ЗУРАГ 8.3



ЗУРАГ 8.4



ЗУРАГ 8.5

БООДЛОГЫН ХОРОО Бүтэцтэй бодлогын хороо Бидний ирээдүй Хүн төвтэй нийтийн эрүүл мэнд Нээлттэй хэлэлцүүлэг Drive Globally 4P-PP	
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР	
13:30	Оролцогчдын бүртгэл
14:00	Нээлт, танилцуулга УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн бодлогын хорооны дарга Д.Ганмаа
14:20	МУ-ын Засгийн газраас Нийгмийн эрүүл мэндийн талаар баримталж буй бодлого МУ-ын Ерөнхий Сайд Н. Урал
14:30	Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн үр дүн Эрүүл Мэндийн Сайд Э. Батсүрэг
14:40	"4P" Хэлэлцүүлэг PREVENTION PROMOTION PROTECTION PREPAREDNESS
15:40	Бидний ирээдүй – Нийтийн эрүүл мэнд УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн бодлогын хорооны дарга Д.Ганмаа
16:00	Хэлэлцүүлгээс гарсан чиглэлийг танилцуулах УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн бодлогын хорооны дарга Д.Ганмаа
16:30	Хавалт УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн бодлогын хорооны дарга Д.Ганмаа

Зураг 9.1



Агуулга

1.Эмнэлзүй зохицуулалтын алба	3
2.Эм зүйн алба	4
4.Инженер байгууламжийн алба	5
5.Эмнэлгийн тоног тохоромжийн алба	6
6.Ариутгал халдваргүйтгэлийн тасаг	7
7.Сургалт гадаад харилцааны алба	8
8.Нийгмийн эрүүл мэнд, тандагтын алба	9
9.Мэдээлэл технологийн алба	10
10.Аж ахуй, үйлчилгээний алба	11
11.Хоол шим тэжээлийн тасаг	12
12.Автограшгийн тасаг	13
13.Зайн оношилгооны тов	14

Цахим мэдээ

Эмнэлзүй зохицуулалтын алба

Эмнэлзүйн зохицуулалтын алба 2026 оны I улиралд үндсэн чиг үүргээ 100%-ийн биелэлттэй хэрэгжүүлж, ЭМДБГ-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дунджаар 39.1%-иар давуулан биелүүлсэн. Тайлант хугацаанд нийт хэвтэн эмчлүүлэх амбулатор, дүрс оношилгоо, яаралтай болон телемедициний 110 мянга гаруй тусламж үйлчилгээний нэхэмжлэлийг амжилттай илгээж, санхүүгийн хасагдлыг бууруулах чиглэлээр хяналт, сургалт, дүн шинжилгээг тогтмол зохион байгуулсан. Нийгмийн болон гадаад хамтын ажиллагааны хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг татан төвлөрүүлэн ажиллаж байна.

-3-

Цахим мэдээ

Ариутгал халдваргүйтгэлийн тасаг

АХТ-ын 2026 оны эхний улиралд хийсэн үйл ажиллагааны товч мэдээлэл:

- 145,160 ширхэг багаж ариутгасан
- 214,800 кг зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угааж, индүүдсэн
- 14 төрлийн 1300 ш оёдол хийсэн
- 52 удаагийн орчны халдваргүйтэл хийсэн
- 20.6 тн аюултай хог хаягдал цуглуулсан байна.

"ЭТҮХХ" сэжигтэй болон батлагдсан тохиолдлын талцалтын үйл ажиллагаа тасралтгүй хийж байна. 2026 оны эхний улиралын байдлаар нийт сэрэмжлүүлэх бичиг биетний тоо 28, сэжигтэй тохиолдол 245, үүнээс гаднаас ирсэн халдвар III тохиолдолыг бүртгэсэн байна. Үүнээс батлагдсан тохиолдол нийт 34 байна. Халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр 366 хүнд 16 удаагийн сургалт зохион байгуулжээ.

-7-

ТАЙЛАН ХЯНАСАН

УХТЭ-ИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ДЭД ЗАХИРАЛ:

Д. ЦОГТ-ОЧИР

ТАЙЛАН БИЧСЭН

НЭМ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ч. ГҮНЧИРХОРЛОО

НЭМ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН:

Ө. УНДАРМАА